

УНШИГЧДЫН ХҮСЭЛТЭЭР Асуулт-хариулт

/Сэлэнгэ аймгийн Цагаан толгойн ХАА-н ТМДС-ийн багш Ё. Төмөрбаатар Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сүүлийн үеийн байдлыг сонирхож тавьсан асуултанд тус ДДСХ-ийн эш ажилтан Л. Бэгзжав хариулж байна/

Асуулт: «Хятадын онцлогтой социализм» гэдэг томъёололыг тодруулна уу.

Хариулт: БНХАУ-д өөрчлөн байгуулалт хийж эхэлсэн 1979 оноос «Хятадын онцлогтой социализм» байгуулах сэдвийг тус орны удирдагчид удаа дараа хөндөж байв. Дэн Сяопин ХКН-ЫН XII Их хурлыг (1982 оны IX сар) нээж хэлсэн үгэндээ дээрх сэдвийг анх томъёолж: «Марксизмын түгээмэл үнэнийг манай орны тодорхой бодит байдалтай холбох, өөрийн замаар явж, Хятадын онцлогтой социализм байгуулах нь урт хугацааны түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр бидний хийсэн гол дүгнэлт юм» гэжээ.

БНХАУ байгуулагдсанаас хойшхи 40 жилд тус орон хөгжлийн бэрхшээлтэй зам туулахдаа алдаж оносон боловч Хятадад социализм бодит зүйл байлаа. ХКН-ын албан ёсны баримт бичгүүдэд тус орны социализм анхан шатандаа байгаа бөгөөд 1949 онд эхэлсэн энэ шат барагцаалбал 100 жил буюу 2050 он хүртэл үргэлжилнэ гэдгийг заан тэмдэглэжээ. ХКН-ын XIII их хурлаас тус орны үйлдвэрлэх хүчинг хөгжүүлэхийг нийгмийн үндсэн зорилт гэж үзэж, социализмын анхан шатанд ядуу зүдүү байдал хоцрогдлыг арилгах, газар тариалангийн орноос орчин үеийн аж үйлвэрийн орон болгох чиг заалт гаргасан юм. Дэн Сяопин «Социализм байгуулахдаа юуны өмнө социализм гэж юу вэ гэдгийг тодорхой болгох хэрэгтэй. Ядуу зүдүү байдал бол хэрхэвч социализм биш» гэж хэлсэн юм.

Хятадын онцлогтой социализм гэдэг нь улс орон, ард түмнийх нь түүх, уламжлалтай холбоо бүхий онцлог шинж, өвөрмөц байдлын бүрдэл, цогц шинжтэй ойлголт юм. Үүнээс гадна социалист бусад орны онол практикаас ялгарах «өвөрмөц онцлогийг» ч тусгаж байна. ХКН-аас дэвшүүлсэн Хятадын онцлогтой социализм байгуулах зорилт нь социализмын тухай ойлголтыг баяжуулах, социализмын хэв загварын тухай урьдах төсөөлөлөөс ангижрах, хөгжлийн өөр өөр зам сонгон авах бололцоотойг харуулж байна. Гэхдээ энэ нь социализмын түгээмэл зүй тогтол, зарчмыг бүрмөсөн үгүйсгэнэ гэсэн хэрэг биш. Харин ч социализмын түгээмэл зүй тогтлын ач холбогдол өсч буйг социализмын хэдэн арван жилийн туршлага нотолсоор байгаа билээ. Хятадад социализмыг 30 жил байгуулж байгаа боловч одоо хүртэл эхэн шатандаа байсаар буйгаар барахгүй бүр 100 жил болгож сунгалаа гэх мэтээр санал зөрөх явдал гарч байгаа боловч социализмын тухай ойлголт түүнийг байгуулах арга замыг зөв тодорхойлж, догматизмтай тэмцэхэд социализмын эхэн шатны тухай томъёолол дөхөм үзүүлэх нь дамжиггүй.

Асуулт: «Нэг улс-хоёр систем» гэдэг баримтлал юу вэ?

Хариулт: Түүхэн онцлогоос шалтгаалан хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг боловч одоогоор Англи, Протугалийн мэдэлд тус тус байгаа Гонконг, Макао, Гомиьнданы засаглал тогтож буй Тайвань арлыг Хятадын эх хуурай газарт нэгтгэх бодлогын үндэслэл нь «нэг улс-хоёр нийгмийн байгуулал» гэдэг үзэл санаа юм. Хятадын социализмыг түгээмэл зүй тогтлоос ангид, өвөрмөц онцлогтой болгож байгаа энэ үзлээр бол Хятад улсын дотор нийгмийн хоёр өөр байгуулал-социализм капитализм хоёр зэрэгцэн оршиж болох аж. Өөрөөр хэлбэл, Гонконг Макаог нэгтгэн Хятадын засаг захиргааны онцгой район болгосныхоо дараа тэндэх нийгмийн капиталист байгуулалыг наанадаж 50 жил өөрчилөхгүй гэж хятадад зарлаж байна. Хятадын эдийн засгийн хөгжлийн одоогийн хурдац дээр (1988 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3,7 % хөгжингүй орнуудынх 3,8%, хөгжиж буй орнуудынх 3,6%, ЗХУ, Дорнод Европын орнуудынх 4%, Азийн «4 барынх» 10%, Хятадын 11,2% байв). Азийн «4 барын» нэг Гонконгийн үндэсний үйлдвэрлэл нэмэгдэхлээр 2000 оны эхээр тус орны хөгжлийн түвшин эрс нэмэгдэх бас нэг онцлог шинж харагдаж байна.

Асуулт: Хятадын нээлттэй хаалгын» бодлого амжилт олж байна уу?

Хариулт: БНХАУ-ын «Нээлттэй бодлого» тус орны нийгэм эдийн засгийн дотоод амьдралд ч, гадаад харилцааны салбарт ч эрчимтэй явагдаж байна. 1989 оны мэдээгээр Хятад улс дэлхийн 180 гаруй улс, бүс нутагтай худалдаа эдийн засгийн харилцаатай, гадаадтай хамтарч буюу гадаадынх дангаараа хөрөнгө оруулсан үйлдвэр аж ахуйн газар 15 мянга орчим болжээ. БНХАУ гадаадын капиталыг ашиглах, гадаад улс төрийн бодлогоо үзэл суртлаас ангид эдийн засгийн идэвхтэй хамтын ажиллагаанд чиглүүлэх талаар социалист орнуудаас харьцангуй ахисан байна.

Арван жилийн өмнө, социалист орнуудаас Югослав, Унгарын дараа эхэлсэн Хятадын өөрчлөн байгуулалт одоо социалист орнуудад хийж буй өөрчлөн байгуулалттай адил төстэй нийтлэг тал олон байгаагийн зэрэгцээ хэрэгжүүлж буй арга замын тухайд өвөрмөц онцлог цөөнгүй байна. Хятадын онцлогтой социализм байгуулахаар ХКН-аас дэвшүүлсэн зорилт саад бэрхшээлтэй тулгарч байгаа ч амжилттай хэрэгжиж байгаа нь социализмын онол практикийг баяжуулахад хувь хандив оруулах нь эргэлзээгүй. Чухам үүнийг улирах цаг хугацаа харуулна.

Асуулт: БНХАУ сүүлийн үед социалист болон капиталист оронтой харилцахдаа ямар чиглэлийг гол болгож байна.

Хариулт: ХКН-ын XII их хурал БНХАУ олон улсын тавцанд бие даасан, хараат бус бодлого баримтлахаа тунхагласан билээ. 1986 оны 3-р сард БХАТХ-ын VI удаагийн IV чуулганаар баталсан «БНХАУ-ын бие даасан хараат бус, энх тайванч гадаад бодлогын гол чиглэл, үндсэн зарчим» хэмээх баримт бичигт: «Хятад улс урт хугацааны турш нээлттэй бодлогоо хэрэгжүүлж, тэгш эрхтэй, харилцан ашигтай байх үндсэн дээр олон оронтой эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техникийн солилцоо, хамтын ажиллагааг тасралтгүй өргөтгөн хөгжүүлнэ. Хятадын нээлттэй бодлого бүх дэлхийд, капиталист оронд ч, мөн социалист оронд ч, хөгжингүй оронд ч, хөгжиж буй оронд ч нээлттэй байна» гэж заасан юм.

БНХАУ 80-аад оны эхнээс голлох капиталист орнуудтай худалдаа эдийн засаг улс төрийн харилцаагаа өргөтгөн хөгжүүлж эхэлсэн бөгөөд энэ үед ихэнд социалист оронтой харилцаа хэвийн бус байлаа. Гэвч 80-аад оны дунд үеэс Хятад социалист орнуудын харилцаанд сайн тийш үндсэн өөрчлөлт гарсан нь эдийн засаг, худалдааны олон талт харилцааг хөгжүүлэхийг шаардсан Хятадын дотоод амьдрал, практикт нийцсэн юм. Хятад улс үзэл суртлын ялгаа, нийгмийн байгууллыг үл харгалзан, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх; харилцан үл довтолцох, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох; эрх тэгш, харилцан ашигтай байх; энх тайвнаар зэрэгцэн орших гэсэн 5 зарчмын үндсэн дээр бүх оронтой харилцаа тогтоон хөгжүүлэх ёстой гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын олон улсын харилцаа 3 үндсэн чиглэлээр, тухайлбал капиталист, социалист, хөгжиж буй орнуудтай эрс идэвхижлээ. Одоо тус улс дэлхийн 137 оронтой дипломат, 180 гаруй улс, бүс нутагтай худалдаа эдийн засаг, 130 гаруй оронтой соёлын идэвхтэй харилцаатай байна. 1986 оны байдлаар Хятадын гадаадтай хийж буй худалдаанд капиталист орнууд 55,3%, социалист орнууд 9,2%, хөгжиж буй орнууд, 14,6%, Гонконг, Макао 20,9%-ийг эзэлж байв. Сүүлийн жилүүдэд энэ харьцаа үндсэндээ хэвээр боловч, социалист орнуудын эзлэх хувийн жин өсөх хандлагатай байна.

Капиталист орнуудтай харилцах тухайд гэвэл АНУ, Япон, ХБНГУ, Франц зэрэг голлох капиталист орнуудтай БНХАУ-ын тогтоосон харилцаа түргэн хурдацтай, бүх талаар хөгжиж байна. Жишээлбэл: Хятад-Америкийн худалдаа тус хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон 1979 онд 1 млрд. америк доллар хүрэхгүй байсан бол 1987 онд 8 млрд. америк доллар болж 8 дахин өсчээ. Мөн АНУ-аас Хятадад нийт 3,1 млрд. долларын хөрөнгө оруулсан байна. Хятад-Японы харилцаа хэвийн болсоноос хойшхи 16 жилд (1972—1988) хоёр талын харилцан айлчилсан төлөөлөгчдийн тоо 45 дахин, худалдааны хэмжээ 14 дахин өсч, 106 муж, хошуу, хотын хооронд найрсаг харилцаа тогтжээ. Капиталист орнуудтай тогтоосон харилцаа тус улсын гадаад бодлогын нэн чухал хэсэг болсоор байна. Социалист орнуудтай БНХАУ-ын тогтоосон харилцаа бүрэн хэвийн болох, үйл явц түргэн урагшилж, хөгжлийн шинэ шатанд орлоо гэж хэлж болно. 80-аад оны эхээр зөвхөн БНАСАУ, Румын, Югославтай бүх талын харилцаатай байсан БНХАУ 80-аад оны дунд үеэс социалист бусад орон, түүнчлэн ЗХУ-тай харилцаагаа нам, төрийн дээд хэмжээнд сэргээн хөгжүүлж байна. 1986 оноос эхлэн Польш, БНАГУ, Унгар, Болгар, БНСЧСУ, ЗХУ-тай харилцаагаа бүрэн хэвийн болгосноос гадна Куба, Монгол, Лаостай харилцаагаа сэргээн өргөжүүлж, Вьетнам, Албанитай харилцаагаа сэргээх талаар хэлэлцэн тохиролцох боллоо. Хятад социалист орнуудын хоорондын харилцаанд чанарын шинэ ахиц өөрчлөлт гарч байгаа нь олон улсын харилцаанд бодитойгоор нөлөөлж байна. «Өнгөрснөө хааж ирээдүйгээ харах» гэсэн Хятадын чиг бодлого улс төрийн шинэ сэтгэлгээний хандлагад нийцэж байгаагаараа Хятад социалист орнуудын харилцаа улам хөгжинө гэдэг итгэл төрүүлж байна.